



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 12/55

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01/2376 дугаар албан бичгээр өргөн барьсан саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх “Дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

2. Жагсаалтад орсон түүх соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх, бүрэн бүтэн байдал хадгалалт хамгаалалтыг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж шаардлагатай төсвийг нийслэлийн төсөвт үе шаттай тусган хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалалтад авах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 197 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН




Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн  
12/35 дугаар тогтоолын хавсралт

**ДҮҮРГИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН  
ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ**

Д/д	Түүх, соёлын дурсгалт зүйлсийн нэр	Байршил	Товч тайлбар	Хариуцан хамгаалах байгууллага
<b>БАГАНУУР ДҮҮРЭГ</b>				
1	Д.Нацагдоржийн хөшөө	Багануур дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Нацагдоржийн талбайн дунд	Монголын орчин цагийн уран зохиолыг үндэслэгчийн нэг Дашидоржийн Нацагдоржид зориулсан хөшөөг Багануур дүүрэг байгуулагдсаны 20 жилийн ойг утгаж 1998 онд тухайн үеийн дүүргийн Засаг дарга Д.Эрдэнэбатын санаачлагаар бүтээжээ.	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
2	Бяцханы амны Түрэгийн үеийн цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Түрэгийн үеийн тахилын байгууламж	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
3	Баруун Байдлаг голын зүүн дэнж, Байдлагийн амны хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүрэлийн үеийн дөрвөлжин булш	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
4	Баруун Байдлаг голын зүүн эргийн олон үеийн цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүрэлийн үе, Хүннүгийн үе, Монголын үе зэрэг олон үеийн булш оршуулгын дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
5	Баруун Байдлаг голын зүүн дэнжийн чuluун зэвсгийн дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Чuluун зэвсгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
6	Цохиот хадны хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүрэлийн үеийн Дөрвөлжин булш, хиргисүүр	Багануур дүүргийн Засаг даргын

				Тамгын газар
7	Баруун Байдлаг голын зүүн эрэг, Улаан өндөр уулын өврийн хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
8	Улаан Өндөр уулын олон үеийн цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүннү болон Хүрэлийн үеийн булш оршуулгын дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
9	Улаан Өндөр уулын хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүрэлийн үеийн булш оршуулгын дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
10	Тариан булагийн хиргисүүр, Түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүрэлийн болон Түрэгийн үеийн булш оршуулгын дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
11	Тариан булагийн Залаа хайрхны Хүннүгийн үеийн цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүннүгийн үеийн цогцолбор дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
12	Тариан булагийн зүүн дэнжийн олон үеийн цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүрэл болон Түрэгийн үеийн улш хиргэсүүр	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
13	Тариан булагийн зүүн дэнжийн Түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Түрэгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
14	Тариан булагийн зүүн амны Хүннү, Монголын үеийн дурсгал	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо.	Хүннү болон Монголын үеийн булш оршуулгын дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
15	Баян голын хиргисүүрийн цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 3 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
16	Хэрлэнгийн гүүр орчмын олон үеийн цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 3 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
17	Их Мэлзийн дөрвөлжин булш, Түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгал	Багануур дүүрэг, 3 дугаар хороо	Түрэгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
18	Их Мэлзийн өврийн олон үеийн	Багануур дүүрэг,	Хүрэл болон Монголын үеийн булш	Багануур дүүргийн




	цогцолбор дурсгал	3 дугаар хороо	оршуулгын дурсгал	Засаг даргын Тамгын газар
19	Их Мэлзийн баруун өврийн хиргисүүр, дөрвөлжин булшны дурсгал	Багануур дүүрэг, 3 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
20	Хүрээт довын Хүннүгийн үеийн суурингийн дурсгалт газар	Багануур дүүрэг, 4 дүгээр хороо	Хүннүгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
21	Өндөр довын Хүннүгийн үеийн суурингийн дурсгалт газар	Багануур дүүрэг, 2 дугаар хороо	Хүннүгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
22	Баруун булагийн амны хиргисүүр, дөрвөлжин булшны дурсгал	Багануур дүүрэг, 2 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар

#### БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ


23	Бага баянгийн амны хиргисүүр, дөрвөлжин булшны дурсгалт газар	Багахангай дүүрэг, 2 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар
24	Бага баянгийн амны зүүн бэлийн хиргисүүр, дөрвөлжин булшны дурсгалт газар	Багахангай дүүрэг, 2 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар

#### БАЯНГОЛ ДҮҮРЭГ

25	“Ган зам” өндөрлөг	Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, Тээвэрчдийн гудамж, Нарны замын дундах цэцэрлэгт хүрээлэнд, Улаанбаатар галт тэрэгний буудлын хойд талд	Найрамдлын ган зам өндөрлөгийг 1977 онд ЗХУ-ын мэргэжилтний эх загвараар бүтээжээ.	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
26	П.Н.Шастины цээж баримал	Баянгол дүүрэг,	Монголын ард түмний дунд “Өвгөн	Шастины нэрэмжит



		5 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, П.Н.Шастинь нэрэмжит 3 дугаар эмнэлгийн төв байрны урд	доктор”, “Үхсэн хүнийг сэхээдэг Шастин эмч” хэмээн алдаршсан, ЗХУ- ын хүний гавьяат эмч П.Н.Шастин нь 1923 онд Монголын Засгийн газрын урилгаар Монголд европ эмнэлгийг үүсгэн байгуулах, ард түмнийг эрүүлжүүлэх, эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор иржээ. Энэхүү хүрэл баримлыг 1985 онд Л.Дашзэвэгийн эх загвараар НАХЯ-ны эмнэлгийн үүдэнд босгож, дараа нь Улсын гуравдугаар эмнэлгийн үүдэнд шилжүүлжээ.	Улсын гуравдугаар эмнэлэг
27	“Байгаль эх” цогцолбор	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөөний баруун талд, Баянгол зочид буудлын хашаанд	Энэхүү цогцолборыг 1989 онд П.Зулзагын эх загвараар бүтээжээ.	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
28	Төмөр замын Соёлын ордны барилга	Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөөний хойно, Төмөр замын дээд сургуулийн зүүн талд	Төмөр замын ажилтны орон сууцны хорооллыг боловсрол, соёл, үйлчилгээний төвтэй иж бүрэн байгуулах зорилтын хүрээнд 1959 онд Төмөр замын соёлын ордны барилгыг барьжээ.	Төмөр замын Соёлын ордон
<b>БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ</b>				
29	Д.Сүхбаатарын төрсөн газар гэрэлт хөшөөний хамт	Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо, Жанжны замын хойд талд, Дара эхийн сүмийн зүүн урд талд, Д.Сүхбаатарын төрсөн газар	Төр, цэргийн зүтгэлтэн, 1921 оны Ардын хувьсгалыг удирдан зохион байгуулагчдын нэг Дамдины Сүхбаатар 1893 оны хоёрдугаар сарын 2-нд Их Хүрээний Маймаа хот (одоогийн Амгалан)-ын зүүн монгол хороололд төржээ. 1924 онд Улиастай голын Улаан довын лус тахиж байх	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар




		цэцэрлэгт хүрээлэнгийн дунд	үед эх Ханджав нь Сүхбаатарыг төрүүлсэн газрыг Амгалан дахь Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн гишүүдэд зааж өгснөөр тус газарт овоо босгож, тэмдэгжүүлжээ.	
30	Н.К.Перихийн амьдарч байсан байшин	Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Отгонтэнгэр их сургуулийн зүүн талд	Консулын дэнжид 1903-1905 онд баригдсан орос загварын модон байшинд 1926-1927 онд Николай Константинович Перих гэр бүлийн хамт амьдарч байв.	Н.К.Перихийн гэр музей
31	Улаан хуарангийн хоёр давхар тоосгон барилга	Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн хашаанд	Нийслэл Хүрээний үед Консулын дэнжиин зүүн хойд хэсгийн өндөрлөгт улаан тоосгоор 10 ширхэг барилга баригдсаныг "Улаан хуаран" хэмээн нэрлэх болжээ. Улаан хуарангийн барилгуудаас өдгөө ганцхан барилга хадгалагдан үлдсэн бөгөөд тус барилгад Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн Ахлагчийн сургууль байрлаж байна. Үг барилгыг 1930-аад оны үед Дэmid жанжны шийдвэрээр хоёр давхар болгон өргөтгөжээ.	Үндэсний Батлан хамгаалах их сургууль
32	Монголорын хоёр давхар барилга	Баянзүрх дүүрэг, 22 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Цэргийн төв эмнэлэгийн баруун талд	Консулын дэнж дэх Улаанбаатар хотын анхны европ хийцийн хоёр давхар тоосгон барилгыг Монголор (Mongol-og) хэмээх Бельги-Франц-Орос зэрэг орнуудын хувь нийлүүлсэн олон улсын алтны нийгэмлэг 1902-1905 онд барилсан бөгөөд тус нийгэмлэгийн Монгол дахь төв захиргаа нь энэ барилгад байрлаж байв. Хүрээнийхэн алтны нийгэмлэгийн эзэн Фон Гротын нэрээр "Гротын улаан" хэмээн нэрлэдэг байв.	"Монг-Эм" ХХК



33	Цэргийн госпиталийн төв штаб байрлаж байсан барилга	Баянзүрх дүүрэг, 22 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Цэргийн төв эмнэлгийн хашаанд	Уг хоёр давхар барилга нь 1920-иод оны эхэнд баригдсан. 1925 онд Улаанбаатар хотод анхны нисэх онгоц ирэх үед авсан гэрэл зурагт тус барилга нь Монголорын байшинтай хүзүүвчээр холбогдоноыг үндэслэн уг барилгыг Монголорын барилгаас арай хожуу баригдсан гэж үздэг.	Цэргийн төв эмнэлэг
34	Н.Коперникийн цээж баримал	Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Шинжлэх ухааны академийн 1 дүгээр байрны хашаанд	Алдарт астрономич Н.Коперникийн мэндэлсний 500 жилийн ойд зориулан Польшийн Засгийн газраас 1973 онд Монгол Улсад бэлэглэжээ.	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
35	Г.К.Жуковын цээж баримал	Баянзүрх дүүрэг, 4 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө, Г.К.Жуковын талбайн хойд хэсэгт	БНМАУ-ын баатар, ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, Улаанбаатар хотын хүндэт иргэн, 1939 оны Халх голын байлдааныг командлагч, маршал Георгий Константинович Жуковын үйл хэргийг мөнхжүүлэх зорилгоор 1981 онд барималч С.Доржпаламын эх загвараар бүтээжээ.	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
36	“Монгол ард” эскадрилийн хөшөө	Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөөний зүүн төгсгөлд, Дандарбаатарын гудамж, Улаанхуарангийн гудамжуудын уулзварт	Дэлхийн хоёрдугаар дайны үе буюу 1943 онд Монголын ард түмний хөрөнгөөр Зөвлөлтийн Улаан армид нисэх онгоцны “Монгол ард эскадрил” буюу “Ла-5” загварын байлдааны 12 онгоц бэлэглэсэн түүхийг гэрчлэн харуулсан хөшөө юм. Хөшөөг 1985 онд барималч Л.К.Медянов, Б.Гомбосүрэн нарын эх загвараар Н.Гантэмэр гардан бүтээжээ.	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
37	Төр хурахын амны Айргийн амралт байсан гурван барилга	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Богдхан уулын Төр	Төр хурахын аманд 1946 онд Маршал Х.Чойбалсангийн зуны ордны дан барилгыг барьж, 1960-1963 онд тус	Иргэн Д.Энхчулун 

		хурахын аманд	газарт Айргийн амралтын хоёр давхар хоёр барилгыг нэмж барьжээ.	
38	Хүрэл тогоот дахь Одон орон судлалын төвийн барилга	Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо, Богдхан уулын зүүн хойд үзүүрийн Хүрэл тогоотын аманд	Одон орон судлаач С.Нинжбадгарын санаачилгаар 1956-1957 онд архитектор А.Хишигтийн зураг төслөөр Одон орон судлалын төвийн барилгыг барьжээ.	Одон орон геофизикийн хүрээлэн
39	Их дээндийн амны Түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгал	Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо	Түрэгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
40	Их дээндийн амны хиргисүүрийн дурсгал	Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
41	Их дээндийн амны зүүн бэлийн хүрлийн үеийн цогцолбор дурсгал	Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
42	Их дээндийн амны эхний хиргисүүрийн дурсгал	Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
43	Бага дээндийн амны Түрэгийн үеийн тахилын онгон, цогцолбор дурсгал	Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо	Түрэгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
44	Нарст булан дахь олон үеийн цогцолбор дурсгал	Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо	Олон үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
45	Шар хоолойн Халзангийн амны Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
46	Шашин хурахын амны Сар хад орчмын олон үеийн цогцолбор дурсгал	Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
47	Шавартайн амны адгийн хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
48	Шавартайн амны хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор	Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Баянзүрх дүүргийн Засаг даргын




дурсгал		НАЛАЙХ ДҮҮРЭГ			Тамгын газар
49	Т.Дамдины хөшөө	Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Уул урхайн аврах ангийн хашаанд	Уурхайчин Т.Дамдины хөшөө нь Улаанбаатар хот дахь орчин үеийн анхны хөшөөнүүдийн нэг юм. Тус хөшөөг 1947 онд бүтээжээ.	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	
50	Уурхайчдын 40 жилийн ойн өндөрлөг	Налайх дүүрэг, 3 дугаар хороо, 109 дүгээр сургуулийн зүүн хойд талд	Налайхын уурхай байгуулагдсаны 40 жилийн ойд зориулан 1962 онд энэхүү өндөрлөгийг босгожээ.	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	
51	Налайх дүүргийн өндөрлөг	Налайх дүүрэг, 7 дугаар хороо,	Налайх дүүрэг байгуулагдсаны 20 жилийн ойд зориулан 1982 онд бүтээсэн.	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	
52	Уурхайчин Д.Даваажавын хөшөө	Налайх дүүрэг, 2 дугаар хороо	Монгол Улсын ууган хөдөлмөрийн баатар, уурхайчин Д.Даваажавын дурсгалд зориулан 2000 онд Л.Болдын эх загвараар бүтээсэн.	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	
53	“Уурхайчдын алдар” хөшөө	Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Налайх дүүргийн Соёлын ордны өмнөх талбайд	Энэхүү зэс хөшөөг уурхайчдын алдрыг мөнхлөх зорилгоор 1992 онд Л.Болдын эх загвараар бүтээж, Налайх дүүргийн Соёлын ордны өмнөх талбайд байрлуулжээ.	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	
54	Майхан уулын олон үеийн цогцолбор дурсгал	Налайх дүүрэг, 1 дүгээр хороо	Олон үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	
55	Майхан уулын зүүн бэлийн хиргисүүр, дөрвөлжин булшны дурсгал	Налайх дүүрэг, 1 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	
56	Бүс нуурын хойд энгэрийн Хүннүгийн үеийн дурсгал	Налайх дүүрэг, 5 дугаар хороо	Хүннүгийн үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	
57	Бүс нуурын хойд энгэрийн олон үеийн цогцолбор дурсгал	Налайх дүүрэг, 1 дүгээр хороо	Олон үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	


58	Городок тосгоны Хүннүгийн үеийн дурсгал	Налайх дүүрэг, 5 дугаар хороо	Хүннүгийн үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
59	Гандан амны хиргисүүр, дөрвөлжин булшны дурсгал	Налайх дүүрэг, 5 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
60	Хөх уулын хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Налайх дүүрэг, 1 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үе, Монголын үе зэрэг олон үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
61	Агуйт хадны чулуун зэвсгийн дурсгал	Налайх дүүрэг, 5 дугаар хороо	Чулуун зэвсгийн үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
62	Ар бургастайн амны адгийн Түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгал	Налайх дүүрэг, 1 дүгээр хороо	Түрэгийн үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
63	Өвөр горхийн хиргисүүрийн дурсгал	Налайх дүүрэг, 1 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар
64	Бичигт хясааны хадны зураг	Налайх дүүрэг, 1 дүгээр хороо	Байгалийн улаан зосоор будсан, дөрвөлжин хашлага, дотроо олон бүдэг цэгтэй, хажууд нь зогсоо хүний дүрслэлтэй археологийн судалгаанд Сэлэнгийн хэмээх тодосгодог хадны зураг зонхилдог. Уг зосон зургийн хажууханд 1 м орчим зйтай Ум Ма Ни Бад Мэ Хом гэсэн тарнийн үг бүхий Төвөд бичээстэй. Ойр орчмын хад чулуунд цагаан будгаар орос, монголоор бичсэн бичээнүүд байна.	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар

### СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

65	Найрамдал зуслангийн "Цагаан хаалга"	Сонгинохайрхан дүүрэг, 1 дүгээр хороо, Баянголын ам	Найрамдлын цагаан хаалгыг 1981 онд барьжээ.	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
66	Жаргалант тосгон дахь Д.Сүхбаатарын цээж баримал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр	Д.Сүхбаатарын цээж баримлыг 1976 онд бүтээсэн.	Сонгинохайрхан дүүргийн Засаг



		хороо, Жаргалант тосгоны Соёлын ордны өмнө талбай		даргын Тамгын газар
67	Ар гүнтийн амны хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
68	Ар гүнтийн амны олон үеийн цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэлийн үе, Монголын үе зэрэг олон үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
69	Цагаан чулуутын хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
70	Цагаан чулуутын дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үе болон тодорхойлох боломжгүй 2 дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
71	Хайлааст уулын дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
72	Ар Шижирийн амны хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
73	Ар Шижирийн амны дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
74	Эмээлтийн дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 32 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
75	Соёндын амны хиргисүүр,	Сонгинохайрхан	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан




	дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	дүүрэг, 21 дүгээр хороо		дүүргийн Засаг даргын Тамгын газар
76	361 дүгээр гарам орчмын дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
77	Соёондын амны дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
78	Бурхантын амны Түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
79	Цагаан бургасын амны дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар


#### СҮХБААТАР ДҮҮРЭГ

	Хүн чулууны хонхор, гэрэлт хөшөөний хамт	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Централ таурын зүүн талд	1639 онд Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг Халх Монголын бурхны шашны тэргүүнд өргөмжлөн, орд өргөө байгуулж өгснөөр Улаанбаатар хотын үүсэл тавигджээ. 1706 онд Өргөө Их хүрээ болон өргөжиж, 1719-1778 оны хооронд 21 удаа нүүдэллэжээ. 1778 онд Их хүрээ сүүлчийн нүүдлээрээ Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх хэмээх дөрвөн уулын дунд, Туул, Сэлбэ голын сав, Хүн чулууны хонхорт ирж баттай суурьшсан ажээ. Энэхүү түүхэн үйл явдалд зориулан 1994 онд Хүн чулууны хонхорт дурсгалын мэлхийт хөшөө босгосон.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
80				

81	Сүхбаатарын талбай, Д.Сүхбаатарын морьтой хөшөөний хамт	Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Төрийн ордны өмнө талд	1921 оны 7 дугаар сарын 11-нд Нийслэл Хүрээний гол чөлөөний зүүн өмнө, одоогийн Дуурь бүжгийн эрдмийн театрын өмнөхөн улаан хүрэн өнгөтэй модон индэр байгуулж, Ардын хувьсгалын ялалтыг зарлан тунхаглажээ. Энэхүү үйл явдлын үр дүнд Нийслэл хүрээнд шинэ төв талбай үүсэж, “Индрийн талбай” хэмээн нэрлэх болжээ. 1946 онд Индэрийн талбайн төв дунд С.Чоймболын зураг төслөөр Д.Сүхбаатарын морьтой хөшөөг байгуулж, талбайн нэрийг “Д.Сүхбаатарын талбай” хэмээн нэрлэжээ.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
82	Улсын Драмын эрдмийн театрын барилга	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Сөүлийн гудамжны зүүн үзүүрийн өмнө талд	1956 онд нийслэлийн Хувьсгалт Залуучуудын эвлэлийн гишүүдээс Залуучуудын ордон барих санаачилга гарч, зураг төслийг архитектор Б.Чимэд зохиож, 1960 онд барьж ашиглалтад оруулжээ. 1963 оны тавдугаар сард уг барилгад Улсын драмын эрдмийн театр, Үндэсний дуу, бүжгийн чуулга зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагууд байрлах болсноор Драмын театрын барилга гэж нэрлэгдэх болжээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бүрдүүлдэг барилгын нэг юм.	Улсын Драмын эрдмийн театр
83	БНМАУ-ын Засгийн газар 1930-1951 онд байрлаж байсан барилга	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Бага тойруугийн	Нийслэл хүрээний уед “Хүрээний сайдын яам” хэмээх Дотоод яам байсан газар дээр 1929-1930 онд хоёр давхар барилга бариулсан бөгөөд тус барилгад 1930-1951 онд БНМАУ-ын	Монгол Улсын Боловсролын их сургууль




		гудамжны уулзварын зүүн хойд талд	Засгийн газар байрлаж байв. Тус түүхэн барилгад 1951 оноос одоог хүртэл Монгол Улсын Боловсролын Их Сургууль байрлаж байна.	
84	Нэгдүгээр сургуулийн барилга	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Сөүлийн гудамжны хойд талд	Улаанбаатар хотын Нэгдүгээр сургууль нь Монгол Улсын анхны дунд сургууль бөгөөд тус сургуулийн байрлаж буй 1940 онд баригдсан барилга нь Улаанбаатар хотын анхны дөрвөн давхар барилга юм.	Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургууль
85	Хүүхдийн Урлан бүтээх төвийн барилга	Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Бага тойруугийн гудамжны хойд талд	Монголын пионерийн ордонг Монголын хоёр дахь архитектор Б.Дамбийнчмын зураг төслөөр барьж, 1958 оны 10 дугаар сард ашиглалтад оруулжээ. 1988 онд тус барилгад Монголын Хүүхдийн урлан бүтээх төв “Пионер сурагчдын сургалт үйлдвэрлэлийн төв” нэртэйгээр байгуулагджээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бүрдүүлдэг барилгын нэг юм.	Хүүхдийн урлан бүтээх төв
86	Монгол Улсын Их сургуулийн хичээлийн нэгдүгээр байр	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ж.Самбуу, Их сургуулийн гудамжны уулзварын зүүн хойд талд	Монгол Улсын их сургуулийн хичээлийн төв барилгыг Зөвлөлтийн архитектор Н.М.Щепетильниковын зураг төсөл, инженер Гуреевичийн удирдлагаар 1947 онд барьж дуусжээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бүрдүүлдэг барилгын нэг юм.	Монгол Улсын их сургууль
87	Х.Чойбалсангийн амьдарч байсан Өвлийн ордон	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Сөүлийн гудамж, Нэгдүгээр сургуулийн зүүн	Улс төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын хошой баатар, өрлөг жанжин, ХХ зууны монголын удирдагчдын нэг Х.Чойбалсанд зориулан архитектор	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар




		талд	Н.М.Щепетильниковын зураг төслөөр 1947 онд уг барилгыг барьжээ. Энэ барилгыг Х.Чойбалсангийн өвлийн ордон, 30 дугаар байр, Маршалын өргөө хэмээн нэрлэдэг бөгөөд Х.Чойбалсан насан өөд болтлоо амьдарч байжээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бурдүүлдэг барилгын нэг юм.	
88	Монгол Улсын Их сургуулийн анхны хичээлийн байр	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөөний өмнө, Гадаад хэргийн яамны зүүн талд	Ардын хувьсгалын эхний жилүүдэд /1926 онд/ улсаас бариулсан анхны барилгуудын нэг нь Оюутны сургуулийн байшин юм. Нийтдээ 20 шахам өрөө, тасалгаа бүхий хоёр давхар тоосгон байшин нь тэр үед хотын гоёмсог барилгын нэгэнд тооцогдож байв.	Зориг сан
89	Үндэсний номын сангийн барилга	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөөний зүүн талд	Уг барилга нь ЗХУ-ын архитектор Н.М.Щепетельниковын зураг төслөөр 1951 онд баригдсан Монгол Улсын номын сангийн зориулалттай анхны барилга юм. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бурдүүлдэг барилгын нэг юм.	Үндэсний Төв номын
90	Гадаад харилцааны яамны барилга	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө, Олимпийн гудамжны уулзварын зүүн урд талд	Тус барилгыг Гадаад харилцааны яамны зориулалтаар архитектор В.Шульгины зураг төслөөр 1947 онд барьж байгуулжээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бурдүүлдэг барилгын нэг юм.	Гадаад харилцааны яам
91	Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын барилга	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын	Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгыг 1949 онд Улсын хөгжимт драмын театр нэрээр барьж	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын



		талбайн зүүн талд	байгуулжээ. Барилга, хашааны монгол хээ угалз, чимэглэлийг архитектор Б.Чимэдийн удирдаж, зураач Д.Манибадар нарын зохиосон зураг төслөөр барималч С.Чоймбол, Н.Даваацэрэн, Н.Жамбаа нар бүтээжээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бүрдүүлдэг барилгын нэг юм.	газар
92	Анхны "40 мянгат" орон сууцны хорооллын 40, 42, 44, 60, 62 дугаар барилга	Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө	БНМАУ, ЗХУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийн хэлэлцээр, ЗХУ-ын санхүү, материал техникийн тусламжаар Улаанбаатар хотод 40 мянган м.кв ашигтай талбай бүхий орон сууцны барилгыг соёл, үйлчилгээний газрын хамт барьж байгуулахаар тохиролцжээ. Хэлэлцээрийн дагуу Москва хотын Гипрогор институттээс Нэгдүгээр дэчин мянгатын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөг зохиож, 1958-1961 онд орон сууцны 3-4 давхар орчин үеийн тохилог 1093 айлын орон сууцыг сургууль, цэцэрлэг, ясли, дэлгүүр, гуанс зэрэг соёл, үйлчилгээний барилгудын хамт барьж ашиглалтад оруулжээ.	- "Соёлч 40 мянгат" СӨХ - "Гал-3" СӨХ
93	Улсын төв поликлиник байрлаж байсан барилга	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Г.Чагдаржавын гудамжны зүүн талд	1946 оны зун МАХН-ын Төв хороо, Улаанбаатар хотын Намын хорооноос нийслэлийн хөдөлмөрчдөд хандан их барилга дээр үндсэн ажлын бус цагт субботникоор ажиллах хөдөлгөөн өрнөжээ. Маршал Чойбалсангийн саналаар их барилгын төсвээс хэмнэгдсэн хөрөнгөөр Улсын төв	Сүхбаатар, Баянгол дүүргийн прокурорын газар




			поликлиникийн барилгыг барихаар тогтох, 1947-1949 онд барьж дуусгажээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бүрдүүлдэг барилгын нэг юм.	
94	МУБИС-ийн Багшийн сургуулийн барилга	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Бага тойруугийн гудамжны зүүн талд	БНМАУ-ын Барилгын зургийн институтын зураг төслөөр 1962 онд Багшийн коллежийн 900 хүүхдийн хичээлийн гурван давхар барилгыг барьж ашиглалтад оруулжээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бүрдүүлдэг барилгын нэг юм.	Монгол Улсын Боловсролын их сургуулийн Багшийн сургууль
95	Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны орон сууцны 1, 2, 24 дүгээр байр	Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Ж.Самбуугийн гудамж болон Төрийн ордны хойд талд	Тус орон сууц нь дайны дараах Энх цагийн бүтээн байгуулалтаар Улаанбаатар хотод баригдсан анхны тохилог орон сууцны барилгын нэг юм. Энэхүү барилгыг 72 айлын орон сууц гэж нэрлэдэг байв. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бүрдүүлдэг барилгын нэг юм.	“Үйлган” СӨХ
96	МУИС-ийн нэгдүгээр байрны өмнөх Х.Чойбалсангийн хөшөө	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ж.Самбуугийн гудамж, Их сургуулийн гудамжны уулзварын зүүн хойд талд	ХХ зууны Монголын улс төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын хошой баатар, маршал Х.Чойбалсангийн хөшөөг 1946 онд С.Чоймболын зураг төслөөр бүтээжээ. Энэхүү хөшөө нь Х.Чойбалсанг амьд ахуйд боссон гэдгээрээ онцлог бөгөөд монгол хүний бүтээсэн орчин цагийн анхны хөшөөний нэг юм.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
97	Д.Нацагдоржийн хөшөө	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Энхтайвны өргөн	Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгч, яруу найрагч Дашдоржийн Нацагдоржид зориулан уг хөшөөг 1966	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын




		чөлөөний хойд талд, Улаанбаатар зочид буудлын өмнөх цэцэрлэгт хүрээлэнд	онд Л.Махбалын зураг төсөл, Н.Жамбаагийн удирдлагаар Монголын урчуудын эвлэлийн хорооны дүрслэх урлагийн баримлын тасгийн урчууд бүтээжээ.	газар
98	В.И.Ульяновын хөшөө	Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Бага тойруугийн гудамжны хойно, Хүүхдийн урлан бүтээх төвийн өмнөх талбайд	Залуу В.И.Лениний хөшөөг 1987 онд Ч.Дашзэвэгийн зураг төслөөр бүтээж, Монголын пионерийн ордон, одоогийн Хүүхдийн урлан бүтээх төвийн үүдэнд байрлуулжээ.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
99	“Саальчин” баримал	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Сөүлийн гудамжны хойно, төрийн тусгай хамгаалалттай “Маршал харш”-ийн хашаан дотор, зүүн урд талд	Х.Чойбалсангийн өвлийн ордон буюу 30 дугаар байрыг барьсны дараа хашаанд нь чимэглэлийн зориулалтаар хэд хэдэн баримал bosгоны нэг нь Саальчин баримал юм. Тус баримлыг Монголын орчин үеийн анхны барималчдын нэг Н.Жамбаагийн эх загвараар 1951 онд бүтээжээ.	Төрийн тусгай хамгаалалтын газар
100	“Барилдаан” баримал	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Сөүлийн гудамжны хойно, төрийн тусгай хамгаалалттай “Маршал харш”-ийн хашаан дотор, зүүн хойд талд	Х.Чойбалсангийн өвлийн ордон буюу 30 дугаар байрыг барьсны дараа хашаанд нь чимэглэлийн зориулалтаар хэд хэдэн баримал bosгоны нэг нь Барилдаан баримал юм. Тус баримлыг Монголын орчин үеийн анхны барималчдын нэг Н.Жамбаа, А.Даваацэрэн нар 1946- 1947 онд бүтээжээ.	Төрийн тусгай хамгаалалтын газар
101	П.Е.Щетинкиний цээж баримал	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө, хуучин Ленин клубын байшингийн баруун талд	Монголчуудын дунд “Төмөрбаатар жанжин” нэрээр алдаршсан П.Е.Щетинкиний цээж баримлыг 1984 онд барималч Ц.Доржсүрэнгийн эх загвараар бүтээжээ. 1921 онд П.Е.Щетинкиний удирдсан улаан	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар




			армийн анги, Монгол ардын журамт цэргийн хамт цагаантны эсрэг байлдан гарамгай гавьяяа байгуулжээ. Мөн 1926 оны наймдугаар сард Монголын Засгийн газрын урилгаар Монгол Улсын Дотоодыг хамгаалах албанда зөвлөх мэргэжилтнээр ажиллаж байжээ.	
102	“Сур харваач” баримал	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Сөүлийн гудамжны хойно, төрийн тусгай хамгаалалттай “Маршал харш”-ийн хашаан дотор, баруун хойд талд	Х.Чойбалсангийн өвлийн ордон буюу 30 дугаар байрыг барьсны дараа хашаанд нь чимэглэлийн зориулалтаар хэд хэдэн баримал босгоны нэг нь Сур харваач баримал юм. Тус баримлыг Монголын орчин үеийн анхны барималчдын нэг Н.Жамбаа, А.Даваацэрэн нар 1946-1947 онд бүтээжээ.	Төрийн тусгай хамгаалалтын газар
103	“Эмнэг сургагч” баримал	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөөний хойно, Централ таурын өмнөх усан оргилуурын дунд	Эмнэг сургагч баримал нь Улаанбаатар хотын орчин цагийн анхны баримлуудын нэг юм. 1948 онд ардын зураач Н.Жамбаа эх загварыг гаргаж, 1958 онд түүний шавь Л.Дашдэлэгээр удирдуулсан УЭХ-ны баримлын тасгийн барималчид хүрлээр цутгаж материалыг сайжруулжээ.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
104	“Адуучин” баримал	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Сөүлийн гудамжны хойно, төрийн тусгай хамгаалалттай “Маршал харш”-ийн хашаан дотор, баруун хойд талд	Х.Чойбалсангийн өвлийн ордон буюу 30 дугаар байрыг барьсны дараа хашаанд нь чимэглэлийн зориулалтаар хэд хэдэн баримал босгоны нэг нь Адуучин баримал юм. Тус баримлыг Монголын орчин үеийн анхны барималчдын нэг Н.Жамбаа 1948 онд бүтээжээ.	Төрийн тусгай хамгаалалтын газар
105	“Анчин” баримал	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,	Х.Чойбалсангийн өвлийн ордон буюу 30 дугаар байрыг барьсны дараа	Төрийн тусгай хамгаалалтын



		Сөүлийн гудамжны хойно, төрийн тусгай хамгаалалттай “Маршал харш”-ийн хашаан дотор, зүүн урд талд	хашаанд нь чимэглэлийн зориулалтаар хэд хэдэн баримал босгоны нэг нь Анчин баримал юм. Тус баримлыг Монголын орчин үеийн анхны барималчдын нэг Н.Жамбаа 1951 онд бүтээжээ.	газар
106	“Эх үрс” баримал	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Улсын клиникийн нэгдүгээр амаржих газрын урд хашаанд	Бадамлянхуа цэцгэн дээр хүүхдээ тэврэн сууж буй эх хүнийг дүрсэлсэн тус баримлыг 1994 онд Г.Баатарцогтын эх загвараар, зэс хөөмлийн аргаар бүтээжээ.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
107	“Гурван унага” баримал	Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Сөүлийн гудамжны урд талд, Өгөөж чихэр боовны үйлдвэрийн баруун урд, 52 дугаар байрны хойд талбайд	Ц.Амгалангийн загвараар 1983 онд бүтээжээ. Уг баримлыг анх Улсын Драмын эрдмийн театрын өмнө талбайд босгосон ба тус талбайг Ю.Цэдэнбалын талбай болгосноор “Өгөөж” компанийн эсрэг талд, угсармал орон сууцны хойд хэсэгт шилжүүлэн байрлуулжээ.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
108	“Хүндийг өргөгч” баримал	Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Хүүхдийн урлан бүтээх төвийн хашааны хойд талд	Хот чимэглэлийн энэ баримлыг 1965 онд барималч С.Чоймболын зураг төслөөр бүтээжээ.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
109	“Нар, байгаль” баримал	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөөний баруун талд, Баянгол зочид буудлын хашаанд	P.Энхтайваны эх загвараар 1983 онд бүтээсэн “Нар, байгаль баримал”-ын төв хэсэг нь нарыг бэлгэдэж, баруун хэсэг нь сансар огторгуй, зүүн хэсэг нь урган соёолж буй цэцгийг дүрсэлсэн ажээ.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
110	“Зээрэнцэг шидэгч” баримал	Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Бага тойруугийн гудамжны хойно, Хүүхдийн урлан	Зээрэнцэг шидэгч баримлыг хот чимэглэлийн зориулалтаар 1965 онд барималч С.Чоймболын зураг төслөөр хийжээ.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар



		бүтээх төвийн хашааны хойд талд		
<b>ХАН-УУЛ ДҮҮРЭГ</b>				
111	Нүхтийн амны Монголын ноёд нууцаар зөвлөлдсөн газар, бичигт хад	Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Богдхан уулын ар, Нүхтийн амны эхэнд, жижиг хадтай толгойн зүүн хойно	1911 оны зун Монголын ноёд, лам нар Орос улсаас тусlamж авах, Манжаас салж, тусгаар улс болох санал сэдэж, нууцаар зөвлөлдөн хэлэлцсэн дурсгалт газар юм.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
112	Соёмбот толгой	Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Богдхан уулын ар, Зайсан толгойн баруун талд	1936 онд Ардын хувьсгалын 15 жилийн ойг тохиолдуулан Соёмбо тэмдэг болон монгол бичгээр "Хувьсгалын 15 жилийн ой мандтугай" гэсэн уриаг чулуугаар шигтгэн бичсэнээс хойш "Соёмбот толгой" гэж нэрлэх болжээ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
113	"Буянт-Ухаа" олон улсын нисэх онгоцны буудал байрлаж байсан хоёр давхар барилга	Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Наадамчдын гудамжны өмнө. Чингис хааны Олон улсын нисэх онгоцны буудлын баруун хойд талд	Монгол, Зөвлөлтийн Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 1956 онд барьж ашиглалтад оруулсан олон улсын нисэх буудлын уг барилгыг 1957 онд Монгол Улсад үнэ төлбөргүй шилжүүлэн өгчээ.	Иргэний нисэхийн ерөнхий газар
114	Монгол Улсын олон улсын анхны нисэх буудал байрлаж байсан байшин	Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын баруун хойно	1930-аад оны дунд үеэс Зөвлөлтийн "Добролёт" байгууллага Улаан-Үд-Улаанбаатар хотын хооронд агаарын тээвэр хийх болсноор нисэх буудал байгуулж "Добр" гэж нэрлэжээ. Монгол Улсын олон улсын анхны нисэх буудлын барилгад 1995 онд Нисэх музей байгуулж, үйл ажиллагаа явуулж байна.	Иргэний нисэхийн ерөнхий газар
115	Удирдлагын академийн хичээлийн төв байр	Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Удирдлагын академийн	МАХН-ын Төв хорооны 1943 оны тавдугаар сарын 20-ны тогтоолоор Намын шинэ хүчний дээд сургуулийн хичээлийн шинэ байр барих шийдвэр	Удирдлагын академи




		гудамжны урд, Богд Жавзандамбын гудамжны зүүн талд	гарчээ. Уг шийдвэрийн дагуу 1600 м.кв талбай бүхий хоёр сая шахам төгрөгийн төсөвт өртөгтэй хоёр давхар хичээлийн байрыг Улсын барилга трестийн барилгачид 1946-1948 онд барьж ашиглалтад оруулжээ.	
116	Д.Сүхбаатарын хөшөө	Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Удирдлагын академийн хичээлийн төв байрны замын хойд талбайд	Д.Сүхбаатарын үйл хэргийг мөнхжүүлэх зорилгоор бүтээсэн хоёр дахь хөшөөг 1947 онд барималч С.Чоймболын эх загвараар бүтээжээ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
117	Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолбор	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Богдхан уулын ар, Соёмбөт толгой, Зайсангийн гудамжны зүүн талд	МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сн3-ийн 1969 оны гуравдугаар сарын 28-ны өдрийн 90/87 дугаар тогтоолоор баталсан зураг төслүйг үндэслэн ерөнхий архитектор А.Хишигтийн удирдлагаар архитектор Т.Мишиг, Н.Уртнасан, Д.Өлзийхишиг, инженер-конструктор С.Я.Кузнецов, И.Баадай, залуу барималч Ц.Доржсүрэн, П.Зулзага, зураач Я.Үржнээ, Б.Доржханд нарын зохиосон шинэ зураг төслөөр Зөвлөлтийн дайчдын дурсгалын хөшөө цогцолборыг 1969-1971 онд барьж байгуулжээ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
118	Ардын хувьсгалын 40 жилийн ойн өндөрлөг	Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Махатма Гандигийн гудамж, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн хойд талд	Уг өндөрлөгийг Улсын барилгын зургийн институтийн архитектор Т.Мишигийн зураг төслөөр Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хойт хэсэгт 1961 оны долдугаар сард барьж босгожээ. Өндөрлөг нь 2 метр суурийн дээр босгосон үндэсний хээ угалз бүхий дөрвөн талт өндөр баганаас бүтсэн бөгөөд орой дээрээ соёмботой.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар



			Дурсгалын баганын оройн хэсэгт соёмбо үсгийг байрлуулж, дунд хэсгийг нь үндэсний хээгээр чимэглэжээ.	
119	Ардын хувьсгалын 25 жилийн ойн өндерлөг	Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Наадамчдын гудамж, Арцатын 18 дугаар гудамжны задгай талбайд	1946 онд Ардын хувьсгалын 25 жилийн түүхт ойн дурсгалд зориулсан өндерлөгийг Д.Чойдог, Н.Бельский нарын зураг төслөөр бүтээжээ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
120	“Хувьсгалт Монгол” танкны хөшөө	Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсан толгойн хойд талд	1968 онд “Хувьсгалт Монгол” танкийн бригадын 25 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотын Ажилчны районы нутаг дэвсгэрт “Хувьсгалт Монгол” танкийн бригадын дурсгалын хөшөөг босгожээ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
121	“Ажилчны алдар” хөшөө	Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөөний хойд хэсэг, 19-ийн автобусны буудлын хойд талын талбайн дунд	1934 онд Улаанбаатар хотод Монголын анхны аж үйлдвэрийн комбинат байгуулагдсанаар ажилчин анги бий болжээ. Энэхүү түүхэн үйл явдалд зориулан 1989 онд барималч Б.Хийморийн зураг төслөөр бүтээжээ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
122	Богдын Шар ордны үүдэнд байсан хоёр чулуун арслан	Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Богд хааны ордон музейн хашаанд	Монголын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамба хутагтын төрийн Шар ордны өмнөх шөргөн хашааны үүдэнд байсан хос арсланг 1956 онд Улсын төв музей буюу Байгалийн түүхийн музейн өмнө зөөж тавьжээ. 2018 онд уг хоёр арсланг Богд хааны ордон музейн Амгалан-Энхийн хаалганы өмнө шилжүүлэн байрлуулсан.	Богд хааны ордон музей
123	Сонгины амралтын цогцолбор барилга	Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо, Туул голын хойд талд	1964 онд Монгол Улсын хоёр дахь архитектор Б.Дамбийнамын зураг төслөөр барьсан бөгөөд Улаанбаатар хот дахь неоклассик загвартай	Сонгины амралтын газар 


			барилгын нэг юм.	
124	Сонгинохайрхан уулын баруун урд үзүүрийн амны хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
125	Сонгинохайрхан уулын баруун үзүүрийн олон үеийн цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо	Олон үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
126	Сонгинохайрхан уулын баруун урд амны эх дэх хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо.	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
127	Эмгэнтийн шандын дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
128	Эмгэнтийн шандын эхний дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
129	Өлзийт хайрхны олон үеийн цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо	Олон үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
130	Өлзийт тосгоны хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
131	Түргэний амны эхний дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 14 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
132	Түргэний амны Түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо	Түрэгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
133	Түргэний амны хиргисүүр, Түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үе болон Түрэгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
134	Түргэний амны хиргисүүр, дөрвөлжин булшны цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо	Хүрэл зэвсгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
135	Түргэний амны Түрэгийн үеийн	Хан-Уул дүүрэг,	Түрэгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн



	тахилын цогцолбор дурсгал	14 дүгээр хороо		Засаг даргын Тамгын газар
136	Нүхтийн амны хүрлийн үе, Хүннүгийн үеийн цогцолбор дурсгал	Хан-Уул дүүрэг, 6 дугаар хороо	Хүрэл зэвсгийн үе болон Хүннүгийн үеийн дурсгал	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар

### ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

137	Монголын орчин үеийн анхны "Алтай" зочид буудал байрлаж байсан барилга	Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны барилгын урд талд	Улаанбаатар хотын төвийн хэсгийг шинэчлэн байгуулах төлөвлөгөөний дагуу 1946-1948 онд монголын орчин цагийн зочид буудлын зориулалтаар баригдсан анхны барилга юм. Уг барилга нь сэтын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бурдүүлдэг барилгын нэг юм. Тус барилгад 1964 оноос хойш Хотын захиргаа байрлаж байна.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
138	Хүүхдийн ба баримтат кино театр байрлаж байсан байшин	Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жуулчны гудамж болон Барилгачдын талбайн замын урд талд	Энэхүү барилгад 1934-1966 онд Ард кино театр, 1966-1978 онд Хүүхдийн ба баримтат кино байрлаж байжээ.	Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм
139	Элдэв-Очирын нэрэмжит Хүүхдийн кино театр байрлаж байсан барилга	Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Төв шуудангийн хойд талд	1948 онд Зөвлөлтийн инженер Н.Климовын зураг төслөөр баригдсан Монгол Улсын орчин үеийн кино театрын зориулалттай анхны барилга бөгөөд тус барилгыг японы олзлогдсон цэргүүдээр барилжээ. Уг барилга нь Улаанбаатар хотын төвийн хэсгийн неоклассик загвартай архитектурын чуулгыг бурдүүлдэг барилгын нэг юм.	Монголын хөрөнгийн бирж
140	Анхны европ эмийн сан байрлаж байсан байшин	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Жуулчны гудамж, Барилгачдын талбайн зүүн талд,	Нийслэл хүрээний мах худалдаалах зах буюу Махан довын зүүн талд 1909 онд Хүрээний Оросын консулын бие хамгаалах цэрэг, оросын харьят наарт үйлчлэх европ эмийн санг байгуулжээ.	"Жи Эс Би" ББСБ ХУРЛЫН АЖЛЫН АЛБА

		Дүрслэх урлагийн музейн хойд талд	1921 оны Ардын хувьсгалын дараа уг байшинд Цэргийн оёдлын үйлдвэр, дараа нь Ардын Засгийн Цагдан Сэргийлэх газар ажиллаж байв. 1925 онд Эрүүлийг Хамгаалахын харьяа европ эмнэлэгийн аптекийг тэнд байгуулж, 1930 онд уг байшингийн хойд талд шинэ байшин барьж, Төв аптекийг шилжүүлэн байрлуулжээ.	
141	Шар дэлгүүр байрлаж байсан байшин	Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Жуулчны гудамжны баруун үзүүрт	Улс хоршооллын худалдааг хөгжүүлэх бодлогын хүрээнд нийслэл хотын худалдааны их захад төвлөрч байсан хувийн худалдааны газрууттай өрсөлдж чадахуйц тохилог дэлгүүрийг 1936 онд Монголын эд хэрэглэгчдийн хоршооны хотын хэлтсээс эрхлэн бариулжээ. Уг байшин нь Улаанбаатар хот дахь дэлгүүрийн зориулалттай анхны тохилог тоосгон байшин бөгөөд олон нийтэд “Шар дэлгүүр” гэж алдаршжээ.	“Өргөө фарм” ХХК
142	“Туул” зоогийн газрын барилга	Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жуулчны гудамжны хойд хэсэгт, Барилгачдын талбайн баруун ёмнө талд	1948 онд баригдсан “Туул” зоогийн газрын барилга нь Улаанбаатар хотын анхны нийтийн хоолны үйлчилгээний зориулалттай барилга юм.	“Наран трейд” ХХК
143	Монголын Үйлдвэрчний Төв Зөвлөлийн барилга	Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Сүхбаатарын талбайн баруун талд	Монголын үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөлийн ордонг 1955 онд ашиглалтад оруулжээ. Ордны барилга барих ажилд Монголын барилгын түүхэнд анх удаа 1954 онд цамхагт өргүүр, цахилгаан лент хэрэглэсэн түүхтэй. Тэрчлэн, залуу барилгачин Намсрай 1954 оны наймдугаар сарын	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо 

			20-ны өдөр тус ордны барилга дээр тавтын системээр ажлын найман цагт 31950 ширхэг тоосго өрж хөдөлмөрийн гаралттай амжилт гаргажээ.	
144	"Тагтаатай хүүхдүүд" баримал	Чингэлтэй дүүрэг, З дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Пийс таурын урд талд	"Тагтаатай хүүхдүүд" зэс, хөөмөл баримлыг 1985 онд барималч Ц.Амгалангийн эх загвараар бүтээжээ.	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар

**ДУРСГАЛЫН ТООН ДҮН**

№	Дүүрэг	Дурсгалын тоо
1	Багануур	22
2	Баянгол	4
3	Баянзүрх	20
4	Налайх	16
5	Багахангай	2
6	Сонгинохайрхан	15
7	Сүхбаатар	31
8	Хан-Уул	26
9	Чингэлтэй	8
	<b>Нийт</b>	<b>144</b>

